



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 16 өдөр

Дугаар A/1282

Чингис хот

Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн
бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй
холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4, 11 дүгээр зүйлийн 11.3.2, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 118, 154 дүгээр тогтоол, Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 41, 43, 46 дугаар тушаал, Аймгийн Онцгой комиссын 19 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст халдварт (ковид-19)-ын батлагдсан тохиолдлын тархалтад хийсэн эрсдэлийн үнэлгээний дүгнэлтэд үндэслэн Улаанбаатар хот, аймаг, сум, багийн хооронд хүндэтгэн үзэх шалтгаан (эрүүл мэнд, хүнс, бараа, түлш шатахууны тээвэр, дэд бүтцийн чиглэлээр хийгдэх хөдөлгөөн, албан томилолт, буяны үйл ажиллагаа)-аас бусад орох, гарах хөдөлгөөнийг 2021 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн 18:00 цагаас 2021 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 06:00 цаг хүртэлх хугацаанд хязгаарлаж, холбогдох дүрэм, журмыг хангуулж ажиллахыг Онцгой байдлын газар (хурандаа Ж.Эрдэнэбат), Цагдаагийн газар (хурандаа Б.Батсайхан), Мэргэжлийн хяналтын газар (Б.Сүнгээ), сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

2. Голомтот бүс нутгаас аймаг сумд руу зорчих иргэдээс шалган нэвтрүүлэх цэг дээр түргэвчилсэн оношлуураар шинжилгээ (Монгол Улсын шадар сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2021 оны A/12 дугаар тушаалаар баталсан журмын дагуу) авч оруулахыг Эрүүл мэндийн газар (Л.Мэндбаяр)-т даалгасугай.

3. Төрийн байгууллага 2021 оны 6 дугаар сарын 27-ны өдрийг хүртэл богиносгосон цагаар (09:00-12:00, 14:00-16:00) ажиллуулахыг төрийн байгууллагын дарга, эрхлэгч нарт даалгасугай.


4. Хүүхдэд тавих хараа хяналтыг сайжруулах, коронавируст халдвар (ковид-19)-аас урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэг мэдээлэл, бодит байдлыг бүх шатны боловсролын байгууллагын цахим сүлжээг ашиглан сурталчилан ажиллахыг Боловсрол, соёл урлагын газар (С.Мөнхцэцэг)-т даалгасугай.

5. Эрсдэлт бүлгийн хүн амын хяналтыг сайжруулж, судалгааг гарган байнгын хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн газар (Л.Мэндбаяр), сумдын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

6. Аймгийн хэмжээнд жуулчны бааз, аялал зугаалга, олон нийтийг хамарсан найр, цайллага, овоо тахилга шашны зан үйлийн үйл ажиллагаа зохион байгуулахыг 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 06:00 цаг хүртэл хязгаарласугай.

7. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ц.Чогсомжав), Шуурхай штабын дарга (хурандаа Ж.Эрдэнэбат) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ